

## ХУДАЛДААНЫ ТӨВӨӨС ГАЛТ ЗЭВСЭГ, ГАЛТ ЗЭВСЭГТЭЙ АДИЛТГАХ ХЭРЭГСЭЛ ХУДАЛДАН АВАХ ИРГЭН

**Үйлчилгээний төрөл:** Худалдааны төвөөс галт зэвсэг, галт зэвсэгтэй адилтгах хэрэгсэл худалдан авах /иргэн/


**Шийдвэрлэх хууль, журам:** Галт зэвсгийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.Цагдаагийн байгууллага энэ хуулийн 17.1-д заасан хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын таван өдрийн дотор энэ хуулийн 9.1-д заасан шаардлагыг хангасан иргэнд иргэний үнэмлэх, энэ хуулийн 11.6-т заасан өвчин, гэмтэл согоггүйг тодорхойлсон эрүүл мэндийн хуудсыг үндэслэн, хуулийн этгээдэд хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээг үндэслэн зөвшөөрөл олгоно. Зөвшөөрлийн тухай хуулийн 8.2 дугаар зүйлийн 10.10 дугаар заалт.

**Шийдвэрлэх хугацаа:** ажлын 5 хоног

**Бүрдүүлэх бичиг баримт:**

1. 21 насанд хүрсэн байх
2. Галт зэвсэг худалдан авах хүсэлт
3. Оршин суугаа хаягийн тодорхойлолт /ТҮЦ машины лавлагаа/
4. Иргэний үнэмлэхний хуулбар /ТҮЦ машины лавлагаа/
5. Цээж зураг 2% /2\*3 хэмжээтэй/
6. ЦЕГ-ын тодорхойлолтын мөнгөн шилжүүлгийн баримт /төрийн сан 100900012027 дансанд тодорхойлолтын үнэ 1000 төгрөг/
7. Борлуулагчийн галт зэвсгийн дэлгэрэнгүй бүртгэл
8. Галт зэвсгийн сумны хошуу, хонгионы дээжийг мэдээллийн санд бүртгэсэн тухай тодорхойлолт
9. Галт зэвсэг эзэмших, ашиглах, хадгалах аюулгүй ажиллагааны сургалтад хамрагдсан гэрчилгээний хуулбар. /Цагдаа, дотоодын цэргийн сургалтын нэгдсэн төв 70190092/
10. Галт зэвсэг ашиглахад харшлах өвчин, гэмтэл согоггүйг тодорхойлсон эрүүл мэндийн хуудас. /харьяа дүүргийн эрүүл мэндийн төвөөс А/33 маягт/

**Зөвшөөрлийн загвар:**



**Төлбөр:** Үгүй

**Хураамж:** Үгүй

**Зөвшөөрөл олгох, сунгах үндэслэл журам:** Зөвшөөрлийн тухай хуулийн 5 дугаар бүлэг. Зөвшөөрөл олгох, сунгах журам

**Түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох үндэслэл, журам:** Зөвшөөрлийн тухай хуулийн 6 дугаар бүлэг. Зөвшөөрлийг түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох

**Олгосон, сунгасан, түдгэлзүүлсэн, сэргээсэн, хүчингүй болгосон зөвшөөрлийн талаарх мэдээлэл:** Зөвшөөрлийн цахим сан (<https://license.mn>)-д байршуулсан.

**Зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, салбар төлөөлөгчийн газар:** Зөвшөөрлийн цахим сан (<https://license.mn>)-д байршуулсан.

**Зөвшөөрөл олгосон болон зөвшөөрлийн хүчинтэй хугацаа:** 3 жил

**Зөвшөөрөл олгосон байгууллагын нэр:** Цагдаагийн ерөнхий газрын Бүртгэл хяналтын төв.

**Зөвшөөрөл олгосон байгууллагын хаяг, утасны дугаар:** Сүхбаатар дүүргийн 4 дүгээр хороо 1-р хэсэг хичээнгүй сайд Цэрэндоржийн гудамж Хүсний 50 дугаар дэлгүүрийн өргөтгөлийн байр. Утас: 70191515

**Хариуцсан албан тушаалтны нэр, утасны дугаар:** Ахлах мэргэжилтэн, цагдаагийн дэд хурандаа Б.Баттулга 93081111